

ЭРДЭС БАЯЛГИЙН АСУУДЛААР ГАДААД ДОТООДЫН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

/Лавлагаа-мэдээлэл/

Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа

Танилцуулга

Лавлагаа, мэдээллийг УИХ -ын гишүүн Х. Бадамсүрэнгийн 2009 оны 12 дугаар сарын 07 -ний өдрийн 5/7962 тоот албан бичгээр ирүүлсэн Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор байгуулагдсан ажлын хэсгүүдийн хэрэгцээнд зориулан өөрийн орны болон дэлхийн бусад орнуудын түвшинд харьцуулсан судалгааны ажлын талаарх лавлагаа, мэдээлэл бэлтгэх захиалгын дагуу судалгааны төвийн референт - судлаач Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа нар гүйцэтгэв.

Тус лавлагаа мэдээлэлд ШУА-ийн харъяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд болон Их сургуулиуд тэдгээрийн дэргэдэх судалгаа, шинжилгээний байгууллагын хийсэн судалгааны ажлууд, Дэлхийн банк, Нээлтэй нийгэм форум, Азийн сан, ЭБЭХЯ-ны АМГТХЭГ-ийн УУГ, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, УИХТГ-ын СШОНХТ зэрэг 18 эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын 2003 - 2009 онд хийгдсэн судалгааны 56 ажлын талаарх мэдээллүүд орсон болно.

Эдгээр судалгаа, шинжилгээний ажлыг салбар, чиглэлээр нь ангилж үзвэл Ашигт малтмалын чиглэлээр 31, Эрчим хүчний чиглэлээр 2, Төмөр зам, авто замын чиглэлээр 2, байгаль орчин, экологийн чиглэлээр 6, Салбарын хүний нөөц бүрдүүлэлт, боловсон хүчин, Хавсралт 3, Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэсэн хот суурингийн чиглэлээр 9, уул уурхайн үйлдвэрлэлийн усан хангамжийн чиглэлээр 3 судалгааны ажил хийгджээ.

Тус лавлагаанд орсон судалгааны ажлуудын мэдээлэл нь тухайн судалгааны нэр, огноо, хаана хийгдсэн, судалгааны гол зорилго, товч үр дүнг тоймлон /Хавсралт 1 - Ашигт малтмал, Хавсралт 2 - Эрчим хүч, Хавсралт 3 - Төмөр зам, авто зам, Хавсралт 4 - Байгаль орчин, экологи, Хавсралт 5 - Салбарын хүний нөөцийн бүрдүүлэлт, боловсон хүчин, Хавсралт 6 - Ашигт малтмалын томоохон ордуудад түшиглэсэн хот суурин, Хавсралт 7 - Уул уурхайн усан хангамж/ орууллаа. Судалгааны ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл тухайн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас болон холбогдох сайтад хандан үзэх боломжтой.

* * *

Хавсралт 1.

1. Ашигт малтмал

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
1.1	Монгол улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин бусад орны татварын орчны харьцуулсан судалгаа АМГТХЭГ-ын УУГ2008 оны 6 сар Эх сурвалж: http://www.mrpam.gov.mn	Дэлхийн эдийн засагт уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө, хөгжлийн хандлага, Монгол улсын хууль эрх зүйн орчин олон улсад хэрхэн үнэлэгдэж байгаа голлох ашигт малтмалын үнэ ханшийн цаашдын төлөвийг АМХЭГ-аас судлаж дүгнэлт гаргасан байна.

1.2.	Эрдэс баялагийн зах зээлийн судалгаа дүгнэлт /Зэсийн судалгаа/ АМГТХЭГ-ын УУГ 2008 оны 6 сар Эх сурвалж: http://www.mrpm.gov.mn	Дэлхийн зах зээл дээрх зэсийн эрэлт хэрэгцээ, монгол орны зэсийн үйлдвэрлэлийн хэтийн төлөвийн судалгаа
1.3.	Эрдэс баялагийн зах зээлийн судалгаа дүгнэлт /Нүүрсний судалгаа/ АМГТХЭГ-ын УУГ 2008 оны 6 сар Эх сурвалж: http://www.mrpm.gov.mn	Дэлхийн зах зээл дээрх нүүрсний эрэлт хэрэгцээ, монгол орны нүүрсний үйлдвэрлэлийн хэтийн төлөвийн судалгаа
1.4.	Эрдэс баялагийн зах зээлийн судалгаа дүгнэлт /Хар төмөрлөгийн судалгаа/ АМГТХЭГ-ын УУГ 2008 оны 6 сар Эх сурвалж: http://www.mrpm.gov.mn	Дэлхийн зах зээл дээрх хар төмөрлөгийн эрэлт хэрэгцээ, монгол орны хар төмөрлөгийн үйлдвэрлэлийн хэтийн төлөвийн судалгаа
1.5.	Монгол улсын уул уурхайн салбар: Эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр судалгаа Дэлхийн Банк 2004 он Эх сурвалж: http://www.forum.mn	Энэхүү тайланд Дэлхийн Банкны Газрын тос, байгалийн хий, уул уурхай ба химийн бодисын хэлтсээс хийсэн «Монгол улсын уул уурхайн салбар: Эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр» судалгааны үр дүнг танилцуулсан байна.
1.6.	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз олголт, түүнд тавьж буй хяналт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт Үндэсний аудитын газар-2005 Эх сурвалж: http://www.forum.mn	Монгол Улсын Ерөнхийлөгч, ҮАБЗ-ийн даргын даалгавараар Үндэсний аудитын газраас 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз олголт, түүнд тавьж буй хяналт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийсэн байна.
1.7.	Монгол улсад өнгөт металл болон хар төмөрлөгийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бололцоо судалгаа Германы Техникийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг 2005 он Эх сурвалж: http://www.forum.mn	Судалгааны зорилго нь нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тулгарч буй саад тотгоруудыг олж тогтооход чиглэжээ. Энэхүү судалгаа нь таван бүлгээс бүрдэж байгаа бөгөөд бүлэг тус бүр нь Монголын уул уурхайн салбарын ойрын ирээдүйн хөгжил болон Монгол улсын өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлтэй холбоотой бие даасан асуудлуудыг тусгасан байна. Энэхүү судалгааг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилтээр Үйлдвэр, худалдааны яамтай хамтран хэрэгжүүлж буй Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол-Германы хамтын ажиллагааны “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслийн хүрээнд олгосон судалгааны даалгаврын дагуу гүйцэтгэжээ.

1.8.	Монголд эрдсийн сан байгуулах шаардлага, арга зам Нээлттэй Нийгэм Форум, 2006 Эх сурвалж: http://www.forum.mn	Монголд эрдсийн сан байгуулах нөхцөл, боломжийн талаар судлаач Г.Цогтсайханы гүйцэтгэсэн уг ажил нь олон улсын эрдсийн сангаа зохистой удирдах гэсэн оролдлого, туршлагыг олон талаас нь авч үзэж, Монголын хөрсөнд хамгийн оновчтой хувилбарыг санал болгож буй судалгааны тайлан юм.
1.9.	Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга: Олон Улсын зөвлөх бүлгийн тайлан Нээлттэй Нийгэм Форум 2006 он Эх сурвалж: http://www.forum.mn	Олон Улсын Зөвлөх бүлгийн энэхүү тайланд Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилгын зорилго, зарчим, шалгуурууд, хэрэгжүүлэх хөшүүрэг, тулгарах сорилт, цаашид зохицуулах асуудал зэргийг багтаасан ба дээрх санаачилгыг хэрэгжүүлэх үүрэгтэй төр, засгийн албан тушаалтнууд мөн уул уурхайн компаниудын удирдлагад гарын авлага болохуйц мэдээллийг багтаасан байна.
1.10.	Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд (Оюу Толгойн жишээн дээр гаргасан санал, зөвлөмж) Нээлттэй Нийгэм Форум 2009 он Эх сурвалж: http://www.forum.mn	ННФ болон Орлогын ажиглагч хүрээлэнгийн зөвлөх зөвлөлийн дарга, хуульч Жозеф Бэлл, Дюкийн их сургуулийн профессор, эдийн засагч Роберт Конрад, Орлогын ажиглагч хүрээлэнгийн захирал Карин Лиссакерс нарын 2005-2008 онд гаргасан санал зөвлөмжийн баримт бичгийг нэгтгэн гаргасан байна. Энэхүү ном уул уурхайн салбарын бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, сонирхогч нарт салбарын бодлогын зарим асуудлаар арга зүйн болон практик туслалцаа үзүүлэх гарын авлага хэлбэртэй.
1.11.	Уул уурхайн салбар дахь төрийн оролцоо Нээлттэй Нийгэм Форум Эх сурвалж: http://www.forum.mn	Улсын Их Хурал, Засгийн газар Ашигт малтмалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдсэнтэй холбогдуулан стратегийн бүх орд газарт төр доод тал нь 51 хувийг эзэмшихээр яригдаж байгаа энэ үед шийдвэрийг эцэслэн гаргахын өмнө анхаарч үзэх хэд хэдэн асуудал байгааг тодруулах үүднээс уг судалгааг хийжээ.
1.12.	“Гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компаниудыг дагасан монгол дахь бизнесийн хөгжил” судалгаа Эхлэл Хөгжил” ТББ, 2005 он Эх сурвалж: http://www.forum.mn	Геологи уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдалд хөндлөнгийн байгууллагын зүгээс бодит дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэсэн байна.



1.13.	<p>Зарим бүтээгдэхүүний Үнийн өсөлтийн албан татварын эдийн засгийн нөлөө, эрх зүйн үндэслэлийн судалгааны төсөл Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци</p> <p>Эх сурвалж: http://www.miningmongolia.mn</p>	<p>Судалгааны зорилго нь Гэнэтийн Ашгийн Татварын Хуулийн нийт эдийн засагт үзүүлсэн нөлөөг судлах, хууль эрх зүйн үндэслэлийг шалган тогтооход оршино. Тодруулбал, уг хуулийн төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлого, алт олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн чадавхи, ирээдүйн хөрөнгө оруулалт, борлуулалт, алтны хууль бус наймаа буюу далд эдийн засаг, Монголын нэмэгдсэн өртөг үйлдвэрлэлт зэрэгт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлно. Мөн түүнчлэн уг хуулийн Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, Олон улсын гэрээ, конвенциуд, олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг зэрэгт хэрхэн нийцэж байгааг шалган тогтооно. Ерөнхийд нь авч үзвэл энэхүү судалгаа нь МУУҮА-ийн гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж байгаа хэдий ч Монгол улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, нийт Монголчуудын хувьд өгөөжтэй байх тийм хууль эрх зүйн орчныг төлөвшүүлэхэд судалгааны ажил чиглэгдсэн байна.</p>
1.14.	<p>“Салбарын бодлого зохицуулалтыг үнэлэх судалгаа” Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци</p> <p>Эх сурвалж: http://www.miningmongolia.mn</p>	<p>Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци 2007 онд Монгол улсын уул уурхайн салбарт болж өнгөрсөн бодлогын шинжтэй томоохон үйл явдлууд тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, санхүү, эдийн засагт хэрхэн нөлөөлсөн талаарх санал, бодол, дуу хоолойг бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад болон олон нийтэд хүргэх зорилгоор санал асуулгыг явуулсан байна.</p>
1.15.	<p>Дэлхийн Ураны зах зээл, цөмийн аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, бусад орнуудын эрх зүйн орчны талаархи харьцуулсан судалгаа-мэдээлэл УИХТГ-ын СШОНХТ, 2009 он</p> <p>Эх сурвалж: http://www.parliament.mn</p>	<p>Дэлхийн ураны зах зээл, олборлох, ашиглах харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны харьцуулсан судалгаа, бусад орнуудын туршлагыг судалж, Монгол Улсын Ураны хайгуул, нөөц, олборлолтын мэдээлэл, Цацрагийн асуудлаар Монгол Улсын хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, уран ашиглах, олборлох харилцааг зохицуулах шаардлага, Олон улсын атомын энергийн аюулгүй байдлын стандартад нийцэж байгаа эсэх талаархи судалгаа</p>



1.16	<p>Ашигт малтмалын орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи харьцуулсан судалгаа, бусад орнуудын туршлага</p> <p>УИХТГ-ын СШОНХТ, 2009 он</p> <p>Эх сурвалж: http://www.parliament.mn</p>	<p>Тогтвортой байдлын гэрээний тухай ерөнхий ойлголт, бусад орны туршлага, уул уурхайн салбар дахь санхүү, татварын олон улсын туршлагыг судалсан бөгөөд Оюу толгойн орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний зарим асуудлаархи харьцуулалтыг бусад орны жишээн дээр туршлагатай жишиж, уул уурхайн салбар дахь төрийн оролцоонд тулгарч болох бэрхшээлийг тодруулсан.</p>
1.17.	<p>Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаархи судлаачдын шүүмж, зарим харьцуулалт</p> <p>УИХТГ-ын СШОНХТ, 2009 он</p> <p>Эх сурвалж:</p> <p>http://www.parliament.mn</p>	<p>Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар судлаач, мэргэжилтнүүдийн гаргасан санал шүүмжийг нэгтгэсэн дүгнэлт хийж, ашигт малтмалын тухай хуульд оруулсан 2006 оны зарим өөрчлөлт, үр дагаварын талаархи олон нийтийн санал шүүмж /фокус ярилцлагын агуулгын тойм/</p>
1.18.	<p>Ашигт малтмалын салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын /тогтвортой байдлын/ гэрээний талаархи харьцуулсан судалгаа</p> <p>УИХТГ-ын СШОНХТ, 2009 он</p> <p>Эх сурвалж:</p> <p>http://www.parliament.mn</p>	<p>Тогтвортой байдлын гэрээний олон улс дахь туршлага, эрх зүйн зохицуулалтын харьцуулалт</p> <p>Гэрээний үндсэн зарчим, түүний агуулга ямар байгаа, тухайлбал төрийн оролцоо, эзэмшлийн хувь хэмжээг тогтоох зарчим, ашиг хуваарилах зарчим, бүтээгдэхүүн хуваах зарчим зэргийн талаар, тэдгээрийн давуу болон сул талууд</p> <p>Гэрээнд тусгадаг албан татварын талаархи асуудал: Тухайлбал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлдэг эсэх, гэрээний хугацаа дуусаагүй байхад татварын хувь хэмжээ нэмэгдэх, буурах нөхцөлд гэрээгээ өөрчилдөг эсэх, шинээр бий болсон татварын талаар гэрээнд нэмж тусгаж болдог эсэх, гэрээний хугацаа хэдэн жилээр хийдэг, дахин сунгадаг эсэх, сунгах тохиолдолд гэрээндээ өөрчлөлт оруулдаг эсэх,</p> <p>Гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг, зөвхөн гэрээгээр тохиролцсон тохиолдолд өөрчлөлт оруулах эсхүл хууль тогтоомжоор нь өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн байдаг эсэх,</p> <p>Гэрээ байгуулах үйл явцын болон гэрээний хэрэгжилтийн талаар олон нийтэд ил тод мэдээлж байх асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал зэргийг судалсан.</p>

1.19.	Монгол Франц хоёр улсын Ашигт малтмалын тухай хуулийн харьцуулалт УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	Монгол болон Франц хоёр улсын ашигт малтмал ашиглах тухай хуулийн ерөнхий зохицуулалтын харьцуулалтыг хуулиудыг заалт бүрээр нь бус гол зохицуулалтын хэсгүүдээр нь харуулсан. Үүнд: Ашигт малтмалын өмчлөл, ордын ангилал, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих шаардлага, тусгай зөвшөөрөл, түүнийг авахад шаардагдах шалгуур, олборлолтын гэрээ, байгаль орчныг хамгаалах болон бусад хохирол эрсдлээс урьдчилан сэргийлэх, ашигт малтмалаас олох орлого гэсэн асуудлуудыг судалсан.
1.20.	Эх үүсвэр нь уул уурхайн орлогоос бүрддэг баялгийн сангуудын зарчим, үйл ажиллагаа УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	Уул уурхайн орлогоос эх үүсвэр нь бүрддэг баялагийн сангуудын талаар зохицуулалтууд гадаадын зарим орноор /Аляскийн байнгын сан, Чили улсын тогтвортой байдлын сан, Норвеги улсын төрийн тэтгэврийн сан, Казахстан улсын үндэсний сан/ гаргасан лавлагаа - мэдээлэл
1.21.	Монгол Улсын хэмжээнд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа дотоодын болон гадаадын аж ахуй нэгжийн талаархи мэдээлэл УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	Хамтарсан болон гадаадын хөрөнгө оруулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигч улс орнууд Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, талбай Ашигт малтмалын тухай хуулинд анхаарах буюу шинэчлэх шаардлагатай зарим зүйл хүчин төгөлдөр лицензийн статистик мэдээ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төсөл зэргийг тусгасан байна.
1.22.	Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Оюутолгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон Хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд хийсэн шинжилгээ, санал зөвлөмж УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан тогтворжуулсан болон тогтворжуулаагүй татварын төрөл, хувь, хэмжээ түүний үр дагавар, Оюу толгой төслөөс хүртэх хөрөнгө оруулалтын өгөөж, зээл эргэн төлөгдөх хугацааны тооцоо Хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд тусгасан зөрчилтэй асуудлууд, судалгааны дүгнэлт, сайжруулах бодлогын хувилбарууд Айвенхоу майнз групп, түүнд хамааралтай этгээдүүдийн хоорондын холбоо, харилцан хамаарал, компанийн бүтэц, үйл ажиллагаа, хөрөнгийн талаархи судалгаа



1.23.	Нүүрсний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, Монгол улсын нүүрсний экспортыг нэмэгдүүлэх боломж, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаархи судалгаа-мэдээлэл УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	Монгол Улсын нүүрсний зах зээлийн судалгаа, дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал, эрх зүйн орчны судалгаа, нөөц болон үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч орнуудын эрх зүйн орчны мэдээлэл
1.24.	Алт хөтөлбөрийн хэрэгжилтээс үүсэн сөрөг үр дагаварууд УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	“Алт” хөтөлбөр хэдийгээр байгалийн баялагийг эргэлтэнд оруулж, улсын эдийн засагт түлхэц өгсөн боловч, түүний улмаас мал аж ахуй, газар тариалан, экологид учруулсан хохирлыг одоогоор тооцож тодорхойлоогүй бөгөөд уг хөтөлбөрт алт олборлосноор байгаль орчин, экологид учруулах сөрөг үр дагавар, хохирлыг тооцоогүй, эвдэрч сүйдсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх талаар огт тусгаагүй байна. Энэхүү судалгаа мэдээлэлд Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас ирүүлсэн нөхөн сэргээлтийн талаарх тайлан болон нөхөн сэргээлтийн талаар Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тайлан зэргийг харьцуулсан байна.
1.25.	Бичил уурхай болон гар аргаар ашигт малтмал олборлох асуудлыг зохицуулах эрх зүйн орчин, бусад орнуудын туршлага УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	Бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбоотой асуудлыг бичил уурхайн хуулийн төсөл хэлэлцэхтэй холбогдуулан төвийн санаачилгаар хийж гүйцэтгэжээ. Судалгаанд бичил уурхайгаас ашигт малтмал олборлох харилцааг зохицуулж буй эрх зүйн орчинг харьцуулж бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлага, хандлагыг судалж бичил уурхайн үйл ажиллагааны талаарх баримт, мэдээлэл багтаасан байна.
1.26.	Монголын уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар ба тогтвортой байдлын гэрээ Сангийн яам, АНУ-ын ОУХА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, 2004 он Эх сурвалж: http://www.forum.mn	Монгол Улсын Засгийн газар нь уул уурхайн салбарт тогтвортой байдлын хэд хэдэн гэрээг байгуулаад байгаа бөгөөд энэхүү тогтвортой байдлын гэрээний тухай асуудал Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлд тусгагдсан байдаг. Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу лиценз эзэмшигч нь гэрээний төслийг хүргүүлэх ёстой. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа өсч байгаа явдал нь бодлого боловсруулагчдын анхаарлыг энэ чиглэл руу татаж байна. Монгол Улсын уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар, тогтвортой байдлын гэрээг бодлогын хэрэгсэл болгон ашиглах тогтолцооны талаарх үнэлгээг АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл, Өрсөлдөх Чадварын Төслийн хүрээнд хийгдсэн байна.

1.27.	Уул уурхайн салбар: Ирээдүй таны гарт Дэлхийн банк, 2005 он Эх сурвалж: http://www.worldbank.org.mn	Судалгаанд салбарыг хөгжүүлэх тааламжтай хүчин зүйл ба саад бэрхшээлийг тодорхойлж, хөрөнгө оруулагчдын төсөөлөл ба эдгээр саад бэрхшээлийг хэрхэн даван туулах талаарх олон улсын тогтсон туршлагын жишиг судалгааг хянан үзэж, хөрөнгө оруулалтын уур амьсгал болон салбарын удирдлагыг сайжруулахад чиглэгдсэн Засгийн газрын арга хэмжээний хувилбаруудын талаар зөвлөмж гаргахын тулд уул уурхайн салбарын өнөөгийн байдлыг дүгнэж үзсэн байна.
1.28	Монгол орны нүүрсний нөөцийн судалгаа “Монгол орны геологи, уул уурхайн ном” Эх сурвалж: www.mining.mn	Монгол улсын шатах ашигт малтмалын геологийн судалгаа, олборлолт хэрэглээний түүхийг бүрэн байдлаар нэгтгэн дүгнэсэн ажил байхгүй бөгөөд 20 дугаар зуунд гүйцэтгэсэн геологийн судалгааны гол үр дүнг тодорхойлж Монгол орны нүүрсний нөөц, орд газруудын зүй тогтол зэргийг судалсан байдлыг нэгтгэн дүгнэх зорилготой. Судалгаагаар Монгол орны нүүрсний нөөц, орд газруудын байршлын зүй тогтолыг зэргийг судалсан байдлыг нэгтгэн дүгнэж, 1960 оноос хойш Монгол орны нүүрсний нөөцөд хийсэн үнэлгээ болон нутаг дэвсгэрийн нүүрсжилтийн мужлалыг бүдүүвчлэн харуулсан байна.
1.29	Монгол орны төмрийн ордуудын судалгаа Эх сурвалж: www.mining.mn	Судалгаанд Монгол орны нутагт өнөөгийн байдлаар төмрийн 17 орд, 100 орчим илрэл тогтоогдсон байна. Судалгаанд 17 ордын байршил, төмрийн илрэлийн төрөл, давхарга, найрлага, хамрах нутаг дэвсгэрийн хэмжээ, агуулга, нөөцийн хэмжээ зэргийг дэлгэрэнгүй байдлаар гаргасан байна.
1.30	Хүдрийн судалгаа Эх сурвалж: www.mining.mn	Уг судалгаанд Төмөр толгойн төмрийн орд нь 7 хүдрийн биетээс бүрдэх бөгөөд зүүн, төв, баруун гэсэн 3 хүдрийн биет болон Төмөртэйн төмрийн ордын хүдрийн биет, түүний тодорхойлолт, найрлага, урьдчилсан хайгуулын ажлын үр дүнд тогтоосон нөөцийн талаарх мэдээллийг хамруулсан байна.
1.31	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц дахь иргэдийн оролцоо Азийн Сан 2007 он Эх сурвалж: www.asianfoundation.mn	Энэхүү гарын авлагад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой төрөөс гаргах шийдвэрт Монгол улсын иргэд хэрхэн хяналт тавьж, мэдээлэл авах талаар уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад иргэд хэзээ, хэрхэн оролцож болохыг тодорхой болгож өгсөн байна.

* * *

Хавсралт 2

2. Эрчим хүч

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
2.1.	Эрчим хүчний технологид ашиглах, хурдасгуур катализатор шингээгч шинэ материалыг эх орны эрдэс түүхий эдээс гаргах технологи Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль 2006-2007 он Эх сурвалж: УИХТГ-ын СШОНХТ	Эх орны эрдэс түүхий эдээс гаргах технологи эрчим хүчний технологид ашиглах шинэ материал гаргаж авах, цеолит болон бусад эрдсийн түүхий эдийг сонгож, минералогийн судалгаа хийж, эрдсийн бүрдэл, физик шинж чанарын судалгаа явуулж, химийн ерөнхий найрлагыг спектрографийн шинжилгээгээр тодорхойлж, цеолитын түүхий эдийн физик химийн үзүүлэлтүүдэд тулгуурлан, хэрэглээний зориулалтыг тогтоожээ. Их, дээд сургууль тэдгээрийн харъяа эрдэм шинжилгээний байгууллагуудад хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа
2.2.	Цахилгаан станцын үнсийг оновчтой технологи ашиглан дахин боловсруулж ангижруулсан төмөр гарган авах технологийн судалгаа Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль 2008-2009 он Эх сурвалж: УИХТГ-ын СШОНХТ	Цахилгаан станциуд өвлийн улиралд хоногт 10000 тонн, зуны улиралд 7000 тонн нүүрс хэрэглэдэг. Зууханд шатаж буй нүүрсний 5% нь үнс болон хаягддаг бөгөөд уг үнсэнд их хэмжээний төмрийн исэл болон бусад металл хольцууд агуулагдаж байгаа хаягдлыг багасгах, хаягдалгүй технологи бий болгох үүднээс цахилгаан станцын үнсийг оновчтой ашиглан дахин боловсруулж ангижруулсан төмөр гарган авах талаарх судалгаа Их, дээд сургууль тэдгээрийн харъяа эрдэм шинжилгээний байгууллагуудад хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа

Хавсралт 3

3. Төмөр зам, авто зам

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
3.1.	Төмөр замын үйлчилгээ ба хэрэглэгчдийн сэтгэл ханамж Нийгмийн Судалгааны Хүрээлэн, 2005 он Эх сурвалж: http://www.forum.mn	Монголын төмөр замын үйл ажиллагааны талаарх харилцагчид, үйлчлүүлэгчдийн санаа бодлыг судлах, тэдгээрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох замаар бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, нэр төрөл, хүрээг өргөжүүлэх арга замын талаар дүгнэлт, практик зөвлөмж боловсруулах зорилготой.

3.2.	<p>Хөрсийг орон нутгийн материалаар (шохой, үнс гэх мэт) бэхжүүлэн авто замын хучилтын суурь үед хэрэглэх технологи</p> <p>Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, 2008-2009 он</p> <p>Эх сурвалж: УИХТГ-ын СШОНХТ</p> <p>Их, дээд сургууль тэдгээрийн харъяа эрдэм шинжилгээний байгууллагуудад хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа</p>	<p>Орон нутгийн нөхцөлд хөрсийг шохой ба үнсээр бэхжүүлэн замын суурь үед хэрэглэх аргачилсан заавар боловсруулж цаашид үндэсний нормативыг боловсруулан батлах үндэс суурь болох зорилготой.</p>
------	--	---

* * *

Хавсралт 4

4. Байгаль орчин, экологи

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
4.1	<p>Монгол орны уул уурхайн салбараас байгаль орчин болон нийгмийн салбарт үзүүлж буй үр нөлөө</p> <p>Дэлхийн банк 2006</p> <p>Эх сурвалж: www.worldbank.org.mn</p>	<p>Судалгааны эмхтгэл нь Монголын уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлж буй гол нөлөөллүүдийг товч дурьдсан байна. Уул уурхайн үйлдвэрлэл явуулж байгаа одоогийн практик ажиллагаа нь үр дүн багатай, маш их ус зарцуулж, гадаргын болон гүний усыг хэтрүүлэн ашигладагас цэвэршүүлэх хэрээс хэтэрсэн, маш их хэмжээний тунамал булингартай хаягдал шингэн үүсэхэд хүргэдэг байна. Түүнчлэн, хууль бусаар ажиллуулж, хаягдал усаа асгаж гол мөрнийг бохирдуулж байгаа нь санаа тавих гол асуудал болж байгаа гэх мэт асуудлуудыг тодруулахад чиглэгдсэн байна.</p>
4.2	<p>Байгаль орчны нөхөн сэргээлтийн талаархи Олон улсын чиг хандлага, Монгол улсад зайлшгүй шаардлагатай эрх зүйн зохицуулалт</p> <p>УИХТГ-ын СШОНХТ, 2009 он</p> <p>Эх сурвалж: СШОНХТ-ийн судалгааны тайлан</p>	<p>Энэхүү бодлогын судалгаагаар уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлтийн өнөөгийн байдлыг мэргэжлийн байгууллагуудын гаргасан тоон үзүүлэлт дээр түшиглэн гаргажээ. Уул уурхайн болон байгалийн бусад баялгийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил болгон ашиглахад "Байгаль орчны шударга ёс, эрх"-ийг хүндэтгэх нь тэрхүү бодлогын тулгуур зарчим юм. Энэхүү судалгаанд дээрх чиглэлийг баримтлан ажиллаж амжилтанд хүрч буй зарим улс орны туршлага, арга зүйг эрх зүйн хүрээнд нь харуулсаны зэрэгцээ, өнөөдөр Монгол улсад хэрэгжүүлж буй байгаль орчныг хамгаалах хууль, эрх зүйн баримт бичигт задлан шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид анхаарах бодлого, зохицуулалтыг санал, зөвлөмж маягаар тусгасан байна.</p>

4.3	Тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн байдал, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: Бодлогын судалгаа, шинжилгээ-1 боть	Уур амьсгалын тааламжтай нөхцлийг бүрдүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлж, олон төрлийн ан амьтан, шувуудын амьдрах орчин болдог байгалийн усны нөөцийг зохицуулах, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, мөнх цэвдэгийг тогтоон барихад гол үүрэг гүйцэтгэдэг ойн сан бүхий газрын хувь хэмжээг судалсан.
4.4	Дархан цаазат Богдхан уулан дах газар ашиглалтын өнөөгийн байдал, гарч буй зөрчил УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: Судалгааны тайлан	Энэхүү судалгаанд Богдхан ууланд 2002-2008 оны байдлаар ТХГН-ийн хуулийн дагуу 391 иргэн, аж ахуйн нэгж 26 аманд газар ашиглах зөвшөөрлийг БОЯ-наас шийдвэр гарч газар олгосон байна. Одоогийн байдлаар 97 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дээрхи аж ахуй нэгжүүд болон ард иргэдийн буруутай үйл ажиллагааны улмаас Богдхан уулын экологийн байдалд учирч буй бэрхшээлүүд, гарч буй үр дагаварын талаар дурьдсан бөгөөд цаашид авч хэрэгжүүлэхүйц арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулсан байна.
4.5	Алт хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи мэдээлэл лавлагаа УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: Судалгааны тайлан	Судалгаанд тус хөтөлбөрийн хүрээнд уул уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээхтэй холбогдуулан гаргасан хууль эрх зүйн баримт бичгүүдийн мэдээлэл мөн уул уурхайн олборлолтонд өртсөн болон нөхөн сэргээлт хийсэн талбайн талаархи мэдээллийг хамруулан хийж гүйцэтгэсэн байна.
4.6	Байгаль орчны менежментийг сайжруулах аргачилсан зөвлөмж Дэлхийн банк 2006 он Эх сурвалж: www.worldbank.org.mn	“Байгаль орчны менежментийн чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах” энэхүү төсөл нь: -байгаль орчны болон байгалийн нөөцийн менежментийн хэрэгцээг үнэлэхэд төрийн байгууллагын чадварыг сайжруулах -байгаль орчны чиглэлээр мөрдөж буй хууль эрхзүйн баримт, байгаль орчныүнэлгээний чадавхийг сайжруулах -байгаль орчны болон байгалийн нөөцийн менежментийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх гэсэн хоорондоо уялдаа бүхий гурван зорилготой.

* * *



5. Салбарын хүний нөөцийн бүрдүүлэлт, боловсон хүчин

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
5.1.	Албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа ОУХБ/АЙПЕК, 2006 он Эх сурвалж: www.forum.mn	Судалгааны гол зорилго нь албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн ажлын нөхцөл байдал, орлого, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын асуудлаар холбогдох мэдээлэл цуглуулж, улсын хэмжээнд хичнээн хүн албан бусаар алт, жонш олборлож байгааг тодорхойлсон байна. Энэхүү судалгаанд албан бусаар алт/жонш олборлож байгаа нийт 21 сум, эдгээр сумдаас 5-17 насны 348 хүүхэд, 18 ба түүнээс дээш насны 232 насанд хүрэгч хамрагдсан бөгөөд улсын хэмжээнд албан бусаар алт, жонш олборлож байгаа 5 ба түүнээс дээш насны нийт 45902 хүн байна гэсэн үр дүн гарчээ. Эдгээр ажиллах хүчний 90 гаруй хувь нь албан бусаар алт олборлож байсан байна.
5.2.	Уул уурхайн зарим салбарт хөдөлмөрийн хүрээн дэх суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль, тогтоомжинд заасан эрхийн хэрэгжилтийн төлөв байдалд хийсэн шалгалт судалгааны тайлан Хүний Эрхийн Үндэсний Комисс 2003 он Эх сурвалж: www.forum.mn	Уул уурхайн албан болон албан бус салбарт ажиллагсдын хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийн төлөв байдал ямар түвшинд байгаа, энэ чиглэлээр хүний эрх ялангуяа хүний хөдөлмөрлөх эрхийн олон улсын суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хүний эрх зөрчигдөж буй шалтгааныг судлан, энэ эрхийг уул уурхайн салбарт хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт, эдийн засаг, нийгэм-сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь энэхүү судалгааг явуулах болжээ. Судалгааг Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос Улсын мэргэжлийн хяналтын газар, МҮЭ-үүдийн холбоо, Монголын ажил олгогч, эздийн нэгдсэн холбооны оролцоотойгоор явуулсан байна.
5.3.	Ажиллах хүчний судалгааны нэгдсэн тайлан Үндэсний Статистикийн Газар 2004 он Эх сурвалж: www.forum.mn	АХС-г ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг судлах зорилгоор 2002-2003 оны 4 улирлыг хамруулан хоёр шатлалт, санамсаргүй түүврийн аргыг ашигласан нь УИХ-аас баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Улаанбаатар хот болон 4 бүс нутгаар (хот, хөдөөгөөр) бүлэглэлт хийж, нийт 9 бүлгээр үр дүнг тооцох боломжтой болсон байна. Судалгааг нэг улиралд 3200 өрх, нийт 12000 гаруй өрхийн гишүүдийг түүвэрлэн сонгосон нь ажиллах хүчний үндсэн үзүүлэлтүүдийг жилийн дөрвөн улирлаар статистикийн аргачлалаар бодитой тооцсон байна.

6. Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэсэн хот суурин

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
6.1.	МУ -ын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарагдах “бичил бүс” тогтоох судалгаа, бусад орнуудын туршлага УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: www.parliament.mn	Төвөөс алслагдсан бүс нутгийн байгалийн онцгой нөхцөлд амьдарч байгаа нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор бүсийн нэмэгдэл олгодог бөгөөд энэ нь онолын үүднээс авч үзвэл эдийн засгийн судалгааны аргаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх бичил бүсүүдийг оновчтой илрүүлэх шаардлагатай болохыг судлагаагаар харуулжээ.
6.2.	Монголын Уул уурхай ба Орон нутгийн хөгжил: Холбоо хамаарлын судалгаа Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци 2009 он. Эх сурвалж: www.miningmongolia.mn	Энэхүү судалгааны нь уул уурхайн компаниуд, Засгийн газар, орон нутаг гэсэн гурван талуудын бие биенээ дэмжсэн урт хугацааны тогтвортой харилцааг хөгжүүлэн, уул уурхайн төслүүдээр дамжин тухайн төсөл хэрэгжиж буй орон нутгийн ард иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэхийн тулд уул уурхайн компаниуд, Засгийн газар, орон нутгийн ард иргэдийн хоорондын хөдөлмөрийн болон бүтээгдэхүүний зах зээл, хууль болон зохицуулалт, байгаль орчин болон нийгмийн асуудлуудаар дамжин хэр оновчтой, үр дүнтэй холбогдож байгааг судлан тогтоосон байна.
6.3.	Тулгуур төвүүд, үйлдвэр, аж ахуйн газрын кластер ба бүс нутгийн хөгжил Азийн Хөгжлийн Банк, 2004 он Эх сурвалж: www.forum.mn	Судалгаа нь МУ-ын БНХ-ийн бодлого, төлөвлөлтийн тодорхой асуудлыг авч үзэж байгаа цуврал баримт бичгийн тавдугаарх нь юм. “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ- ны хүрээнд хийгдсэн ажлын явцад анхаарал татсан сэдвүүдийг сонгон авсан байна.
6.4.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалт Азийн Хөгжлийн Банк, 2004 он Эх сурвалж: www.forum.mn	Судалгаа нь МУ-ын БНХ-ийн бодлого, төлөвлөлтийн тодорхой асуудлыг авч үзэж байгаа цуврал баримт бичгийн долдугаарх нь юм. “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ-ны хүрээнд хийгдсэн ажлын явцад анхаарал татсан сэдвүүдийг сонгон авсан байна.



6.5.	Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх нь Азийн Хөгжлийн Банк, 2004 он Эх сурвалж: :www.forum.mn	Судалгаа нь “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ-ны Төгсгөлийн тайлан юм. ТТ-ны хүрээнд хийсэн ажлын үр дүн, үндсэн дүгнэлтүүдийг энэхүү тайланд тусгажээ.
6.6.	Монгол улсын бүсчилсэн хөгжил Дэлхийн банк, 2005 он Эх сурвалж: www.worldbank.org.mn	Энэхүү бодлогын тэмдэглэл нь тэнцвэртэй бүсийн хөгжилд хүрэх Засгийн газрын зорилтыг дэмжих зорилгоор Монголд үүсэн бий болсон бүсчилсэн динамик, монголын өнөөгийн засгийн газар хоорондын төсвийн зохицуулалт болон Бүсчилсэн Хөгжил ба Эдийн Засгийн Өсөлтийн талаархи олон улсын туршлагаас үлдсэн сургамжуудад хийсэн анализын үндсэн дээр гол гол асуудлуудыг тодорхойлон бодлогын зөвлөмжүүдээр хангах зорилготой.
6.7.	Монгол орны хүн амын газарзүй, хотжилтын орчин үеийн асуудал Шинжлэх ухааны академийн Газар зүйн Хүрээлэн 2005-2007 он Эх сурвалж: УИХТГ-ын СШОНХТ ШУА-ийн харъяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа	<ol style="list-style-type: none"> 1. Монгол улсын хэмжээнд тулгамдсан асуудал болоод байгаа хүн амын шилжих хөдөлгөөн (Их нүүдэл)-ийн одоогийн байдал, шалтгаан, цаашдын төлвийг тодорхойлох. 2. Хөдөөнөөс шилжин ирэгсэд нь Төв тэнхлэгийн дагуу орших Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг хот сууринд ирж нутагших үйл явцыг загварчлан тодорхойлох. 3. Монгол улсын нийгэм эдийн засгийн Төв тэнхлэг үүсэн хөгжих суурь болох төмөр ба засмал замын дагуу хүн амын хөгжлийн зохистой нягтшил (нэг ам км-т 10-аас дээш хүн) бий болж хотжилт үүсч буй одоогийн болон хэтийн төлвийг тодорхойлох 4. Төв тэнхлэгийн дагуух хүн амын хөгжлийн зохистой нягтшил бүхий нутагт “Босоо хөгжил” үүсэх нөхцөл, фермерийн аж ахуй болон үйлдвэржүүлэлт, мал аж ахуй, газар тариалан эрхлэх, аялал жуулчлал хөгжүүлэх боломж, байгаль, нийгэм-эдийн засгийн нөхцөл нөөцийг тогтоох, хэтийн төлвийг тодорхойлох зорилготой.
6.8.	Үйлдвэржилтийн судалгаа өнөө ба ирээдүй /Дархан-Уул, Завхан, Хэнтий аймгийн жишээн дээр/ Монгол Улсын Засгийн Газар Тэргүүн шадар сайдын ажлын алба, Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр, 2009 он	Бүс нутгийг төлөөлөх чадвартай Завхан, Дархан-Уул, Хэнтий аймгуудад үйлдвэрлэл хөгжүүлэх бодит нөөц боломжийг хэрэгцээнд нь тулгуурлан нөлөөлөх хүчин зүйлстэй нь харьцуулан судлах замаар хөгжүүлэх боломжтой үйлдвэрүүдийг тодорхойлох, улмаар тэднийг дэмжих арга замуудыг санал болгоход судалгааны ажил чиглэгджээ.

6.9.	Улаанбаатар хотын ядуурал шилжих хөдөлгөөн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр Хүн амын сургалт, судалгааны төв, 2004он	Монголд сүүлийн жилүүдэд хөдөөгөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал нэмэгдсээр байна. Энэ хандлага Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшин, төлөв байдалд хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилгоор хийгджээ.
------	---	---

* * *

Хавсралт 7

7. Уул уурхайн үйлдвэрлэлийн усан хангамж

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
7.1.	Хүн амын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж НҮБХХ 2004 он Эх сурвалж: http://www.forum.mn	Монгол улсын Засгийн газраас 2004-2005 оныг Усны бодлогын шинэчлэлийн жил болгон зарласан билээ. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллага болох Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан Монгол улсын Засгийн газартай хамтран усан хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн төлөв байдал, Түүнд нөлөөлөх хучин зүйлсийг тодорхойлсон судалгааны баримт бичгийг боловсрууллаа. Мөн энгэхүү судалгаа нь ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх олон нийтийн санаа бодол, усны нөөц болон ус авах, зөөвөрлөхтэй холбогдон гарч буй хүйсийн тэгш бус байдал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн асуудлыг хөндсөн байна.
7.2.	Усны химийн шинжилгээ /гарын авлага/ Дэлхийн банк Эх сурвалж: http://www.worldbank.org.mn	Нидерландын вант улсын Засгийн газрын Итгэлийн сангийн дэмжлэгээр байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн банк хамтран хэрэгжүүлж буй «Байгаль орчны шинэчлэл-2» төслийн хүрээнд боловсруулан гаргав. Усны чанарын хяналт-шинжилгээний болон усны бохирдлын хяналтын байгууллага, лабораториуд, тэдгээрийн инженер, техникийн ажилтан, усны химийн задлан шинжилгээ хийдэг сургалт, үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ, хяналтын нийт лабораторийн химич, шинжээч судлаачид, оюутан сурагчдад зориулжээ.



7.3.	<p>Усны мэдээлэл, зураглал</p> <p>Эх сурвалж: www.worldwildlife.org</p>	<p>Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) -ийн Хамгаалалын судалгааны хөтөлбөр нь одоогоор HydroSHEDS гэж нэрлэгдсэн, дэлхий нийтийн ус зүйн мэдээллийн санг шинэчлэн сайжруулж боловсронгуй болгож байна. Энэхүү өгөгдлийн ихэнх нь дэлхийг бүхэлд хамрах бөгөөд цэвэр усны хамгаалал, байгаль орчны төлөвлөлтийн дүн шинжилгээ, хэрэглээг нэмэгдүүлэхэд зориулагдсан байна.</p>
------	---	--



UIH.MN
СУДАЛГААНЫ САН